

АВТО ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ /2017 оны байдлаар/

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

Тээвэрлэлтийн ангилал	Чиглэл	ААНБ	Тээврийн хэрэгслийн тоо	Зорчигчдын тоо/сая.хүн/
<i>Хот доторх болон хот орчмын тээвэрлэлт</i>	121	39	1932	196.1
<i>Хот хоорондын тээвэрлэлт</i>	80	50	971	2.4
<i>Улс хоорондын байнгын тээвэрлэлт</i>	10	13	91	0.2

Нийслэл хотод нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч 39 аж ахуйн нэгж, байгууллага 121 чиглэлд 1932 тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Хот доторх болон хот орчмын зорчигч тээврээр нийт 196 сая хүн зорчин, зорчигч эргэлт 667.1 сая хүн км болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад зорчигчийн тоо 48,1 сая хүн буюу 19.6 %-иар, зорчигч эргэлт 163.5 сая хүн км буюу 19.4 %-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч 50 аж ахуйн нэгж, байгууллага 80 чиглэлд 971 тээврийн хэрэгсэл, 1215 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. 2017 онд 2.4 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.0%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Улс хоорондын байнгын зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэгч 13 аж ахуйн нэгж, байгууллага 3 улсын 10 чиглэлд 91 тээврийн хэрэгсэл, 112 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. 2017 онд 188,1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10%-иар өссөн үзүүлэлттэй байна.

АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн 241 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан 10 чиглэлд 11125 тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэсэн байна. Экспортын голлох бүтээгдэхүүнийг авч үзвэл:

№	Бүтээгдэхүүний нэр	2016	2017	2017/2016 %
1	Нүүрс	24.2	29.6	121.0
2	Газрын тос	0.95	0.85	89.9
3	Зэсийн баяжмал	0.86	0.65	75.8
4	Төмрийн хүдэр	0.13	1.15	-
Нийт		26.2 сая тн	32.3 сая тн	123.2

2017 онд 29.6 сая.тн нүүрс тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-иар, төмрийн хүдэр 1.150.6 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8 дахин тус тус өссөн бол зэсийн баяжмал 652.1 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 24.2 %-иар, газрын тос 859.9 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 10%-иар нь тус тус буурсан үзүүлэлттэй байна.